Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 30 тайлан нэгтгэснээс 10 байгууллага түүвэрт хамрагдаж, 20 байгууллагад дүгнэлт гаргаснаас 2 байгууллагад “Хязгаарлалттай”, 18 байгууллагад “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн. 1 байгууллага үйл ажиллагаа явуулаагүй байна. Соёлын сайд, Соёл урлагийн газар хязгаарлалттай санал дүгнэлт авсан байна.

4.1 ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ

Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 5,848.3 сая төгрөгийн 41 алдааг аудитын явцад залруулж, залруулагдаагүй нийт 691.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 11.4 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 514.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 35 албан шаардлага хүргүүлж, 165.7 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 37 зөвлөмж өгсөн байна.

4.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 25,392.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 997.6 сая төгрөгийн 6 алдааг залруулж, 0.5 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 24,264.6 сая төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 129.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 997.6 сая төгрөгийн дараах 6 алдааг залруулав. Үүнд:

- ✚ Соёл урлагийн газраас “Түүхийн хүрд” уран сайхны киноны санхүүжилтэд “Монгол кино нэгтгэл ТӨҮГ-т шилжүүлсэн 45.1 сая;
- ✚ Хөрөнгө оруулалтын данснаас техник хяналтын зардлын дансанд 34 удаагийн гүйлгээгээр 302.5 сая төгрөгийг барилга их засварын барьцаа хөрөнгийг шилжүүлж цэвэрлээгүй тайлагнасан.
- ✚ Соёлын яамны аппарат 600.0 сая төгрөгийн газрыг биет бус хөрөнгөөр бүртгээгүй;
- ✚ Үндсэн хөрөнгөөс бараа материалд, бараа материалаас зардалд 42.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг залруулсан.
- ✚ Барьцаа хөрөнгийн данснаас техник хяналтын зардлын дансанд 7.4 сая төгрөгийн шилжүүлж цэвэрлээгүй тайлагнасан.

Төлбөрийн акт

Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолын дагуу өмнөх онд барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан Завхан аймгийн Баянтэс сумын соёлын төвийн барилгын 0.5 сая төгрөгийн хэмнэлтийг улсын төсвийн дансанд төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-т "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл"-ийг төвлөрүүлнэ гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Албан шаардлага

- ✚ Тайлант онд ТНБД-ын холбогдох тушаалуудаар бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас үндсэн хөрөнгө худалдан авахад 631.1 сая, урсгал засварт 200.2 сая төгрөгийг зарцуулсан;
- ✚ Худалдан авалтын ажил үйлчилгээг зохион байгуулахдаа босго үнэд багтаах, нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор худалдан авалтыг уламжлалт аргаар зохион байгуулж, харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан байна.

Эдгээр нь Засгийн газрын 2020 оны "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" 114 дүгээр тогтоолын 3.4-т "Төсвийн урсгал зардлаас дараах зардлын санхүүжилтийг түр зогсоох", 3.4.1 -д "бүх шатны төсвийн байгууллагын гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, сургалт семинар зохион байгуулах, тавилга эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", 34 дүгээр зүйлийн 34.1-д "Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараах нөхцөлд хэрэглэж болно" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг", "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Кино урлагийг дэмжих сан байгуулагдаж, 2020 оны төсвийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр тус санд 10,000.0 сая төгрөгийн төсөв баталсан ба Кино урлагийг дэмжих тухай хууль, сангийн хөрөнгийг зарцуулах журам батлагдаагүйгээс сангийн зарцуулаагүй хөрөнгийн үлдэгдэл сангийн мөнгөн хөрөнгийн дансанд байршиж байна. Энэ нь:

- ✚ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т "Кино урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална" гэж заасан боловч тус журам гараагүй, Кино урлагийг дэмжих тухай хууль батлагдаагүй,
- ✚ Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Тайлант онд Засгийн газрын 2020 оны 253 дугаар тогтоолын дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан Чингис хааны музейн үзмэрүүдийг сэргээн, засварлах, сан хөмрөгийг нэмэгдүүлэх 2,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль журмын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй, гүйцэтгэгч компани, хувь хүн тодорхойгүй, ажлыг гүйцэтгэх үнийн санал аваагүй, төсөвт өртгийг эдийн засгийн үндэслэлтэй тооцож, тооцоолол судалгаа гаргаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", 46.1.3-т "үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлтэд үндэслэн гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг", "үнэн зөв" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолын дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хэрэгжээгүй хөрөнгө оруулалтын 8 ажлын санхүүжилт 4,016.1 сая төгрөгийн үлдэгдэл барьцаа хөрөнгийн дансанд байршсан хэвээр байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар авах зарим арга хэмжээний тухай" 430 дугаар тогтоолын 1.2-т "банкны баталгааг үндэслэн олгосон

санхүүжилт болон барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2020 оны 7 дугаар сарын 30-ны дотор СЯ-ны зөвшөөрлөөр чөлөөлөх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг”, “үнэн зөв” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

- ✚ Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлангийн бусад эргэлтийн хөрөнгө дансанд 2016-2019 онуудад ашиглалтад орсон 9 төсөл арга, хэмжээний 6,108.1 сая, улсын төсвийн санхүүжилт зогссон 1,319.1 сая, нийт 7,417.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй.
- ✚ Мөн 2020 онд ашиглалтад орсон 32 төсөл, арга хэмжээний 54,285.0 сая төгрөгийн барилга байгууламж бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.8-д “хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг”, “үнэн зөв” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Шилэн дансны цахим хуудсанд 61 мэдээлэл байршуулахаас хугацаандаа 46, хугацаа хоцроож 7, байршуулаагүй 8 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 3,409.3 сая төгрөгийн 26 ажил гүйлгээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн оруулав. Үүнд:

1.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Төрийн нарийн бичгийн даргын “Нэмэгдэл хөлс олгох тухай” А/64 тоот тушаалаар зарим албан хаагчдад илүү цагийн хөлс олгохдоо ТНБД өөртөө болон дээд албан тушаалтанд илүү цагийн хөлс олгохоор тушаал гаргасан нь Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6-д “Төрийн нарийн бичгийн дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 9.6.3-т “яамны төсвийн ерөнхий менежерийн хувьд сайдтай үр дүнгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлийг дүгнүүлэх” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Ажилтнуудад цалин хөлсийг олгохдоо холбогдох хууль тогтоомжийн дагуу олгож, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж байх

1.3 Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэгт хамааралгүй, тайлант оны хөтөлбөр арга, хэмжээнд батлагдаагүй ТББ-ын хандивын тоглолтын үйл ажиллагаанд 92.8 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.5-д “батлагдсан төсвийг

зориулалтын дагуу зарцуулах”, 25 дугаар зүйлийн 25.10-т “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.4 Өгсөн зөвлөмж

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж удирдах

1.5 Илрүүлэлт

Сайдын 2020 оны А/72 тоот шагнал олгох тухай тушаалыг үндэслэн Төрийн нарийн бичгийн даргын А/65 дугаар тушаалаар Соёл, урлагийг дэмжих, түүх, соёлын өвийг хамгаалах чиглэлээр үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулахад хувь нэмэр оруулсан гэх үндэслэлээр нэр бүхий 25 ажилтанд мөнгөн шагнал 32.5 сая төгрөгийг цалин, нэмэгдлийн зардлаас зарцуулсан нь Сангийн сайдын 2014 оны Төсвийн эдийн засгийн ангилал батлах тухай 5 дугаар тушаалаар баталсан журмын 6 дугаар хавсралт Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавартай нийцэхгүй байна.

1.6 Өгсөн зөвлөмж

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж удирдах

2.Барьцаа дансны зарцуулалттай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Барилгын чанарын баталгааны барьцаа хөрөнгийн дансанд 28 төсөл арга хэмжээний 2,349.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас 2014-2018 онд үүссэн 4.6 сая төгрөгийн чанарын хяналтын баталгааны барьцаа байршиж байна.

Энэ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, тайлагнах журам”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг”, “үнэн зөв” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Барьцаа дансанд байршиж буй 2014-2018 онуудын засварын ажлын гүйцэтгэлийн чанарын хяналтын баталгааны барьцаа 4.6 сая төгрөгийг зохих журмын дагуу гүйцэтгэгчид олгох.

3.Хөрөнгө оруулалт, их засвар, хөтөлбөр арга хэмжээний дансны зарцуулалттай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт

Хөрөнгө оруулалтын дансны худалдан авалтаас 14 ААНБ-тай хийсэн 2,321.7 сая төгрөг, Хөтөлбөр арга хэмжээний 3 ААНБ-тай хийсэн 2.7 сая төгрөг, нийт 2,324.4 сая төгрөгийн худалдан авалт нь төлбөрийн цахим баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно". Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн”, “үнэн зөв” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж

Хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний зардлын данснаас худалдан авалт хийж буй цахим төлбөрийн баримыг и-баримтаар баталгаажуулж ажиллах.

4. Удирдлагын үйл ажиллагаатай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт

- ✚ Тус яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга хөтөлбөр арга хэмжээний төсвийн зарцуулалтад нэгдүгээр гарын үсэг зурж төсвийг захиран зарцуулсан;
- ✚ Мөн сайдын 2020 оны А/07 дугаар тушаалаар төсвийн зарцуулалт болон гэрээнд гарын үсэг зурах албан тушаалтныг баталсан тушаал нь газруудын чиг үүрэгтэй нийцэхгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-т "дараах албан тушаалтан төсвийн шууд захирагч байна", 16.4.5-д "агентлагийн дарга тус агентлагийн төсвийн" гэж заасантай нийцэхгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж

Газрын чиг үүрэгтэй нийцүүлж, Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах

5. Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Сангийн сайдын баталсан маягт аргачлалын дагуу хөтөлбөр, арга хэмжээний төсөв, гүйцэтгэлийн биелэлт, хүрсэн үр дүн түүний танилцуулга, төсвийн тохируулгын тайлан, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн тайлангийн танилцуулгыг хуулиар заасан хугацаанд иж бүрэн хийж ирүүлээгүй.

Энэ нь

- ✚ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл 54.5-д Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна;
- ✚ Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар батлах журмын 2 дугаар хавсралт;
- ✚ Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар баталсан Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журмын 1 дүгээр хавсралт 1.4-т "Төсвийн эрх захирагч нь төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлант оны төсвийн хэтрэлт, хэмнэлт түүнд нөлөөлсөн хүчин зүйлийн талаарх дэлгэрэнгүй тайлбар танилцуулга хавсаргана" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн", "үнэн зөв" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

5.2 Зөвлөмж

Төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох заавар, журамтай нийцүүлж үнэн зөв тайлагнаж байх.

6. Дотоод хяналттай холбоотой асуудал

6.1 Илрүүлэлт

Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 5,848.3 сая төгрөгийн 41 алдааг аудитын явцад залруулж, залруулагдаагүй нийт 691.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 11.4 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 514.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 35 албан шаардлага хүргүүлж, 165.7 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 37 зөвлөмж өгсөн нь холбогдох хууль, тогтоомж, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй, дотоод хяналт хангалтгүйгээс шалтгаалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.10-д "өөрийн эрхлэх

асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

6.2 Өгсөн зөвлөмж:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байхад анхаарч, дотоод хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Хүснэгт 10. Зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

дд	Харьяа байгууллагууд	Дүгнэлтийн хэлбэр					Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Түүвэр	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн ерөнхийлөн захирагч														
	НИЙТ ДҮН	11	18	2	-	-	93	25,086.5	7	11.9	41	24,779.0	45	295.6
	Соёлын сайд			1			14	14,395.0	1	0.5	5	14,264.6	8	129.9
	ДҮН	-	-	1	-	-	14	14,395	1	1	5	14,265	8	130
Засгийн газрын тусгай сан														
1	Кино урлагийг дэмжих сан	1					1	10,000.0			1	10,000.0		
2	Соёл урлагийг дэмжих сан	1												
	ДҮН	2	0	0	0	0	1	10000.0	0	0.0	1	10000.0	0	0.0
Төрийн өмчит үйлдвэрийн газар														
1	Монгол кино ТӨҮГ		1				3	106.4			2	81.8	1	24.6
	ДҮН		1	0	0	0	3	106.4	0	0	2	81.8	1	24.6
Төсвийн шууд захирагч														
1	Соёлын яам аппарат	1												
2	Соёлын яам /Хөтөлбөр арга хэмжээ/	1												
3	Хөрөнгө оруулалт, их засвар	1												
4	Барьцаа данс	1												
5	Техник хяналт	1												
6	Соёл урлагийн газар			1			5	30.6	1	1.9	2	25.0	2	3.7
7	Үндэсний түүхийн музей		1				6	43.8	1	1.5	2	17.3	3	25.0
8	Байгалийн түүхийн музей		1				3	0.3	-	-	2	0.3	1	-
9	Богд хааны ордон музей		1				3	4.0	-	-	1	-	2	4.0
10	Дүрслэх урлагийн музей		1				2	0.0	-	-	2	-	-	-
11	Театрын музей		1				3	172.6	-	-	2	142.5	1	30.1
12	Чойжин ламын сүм музей		1				5	33.6	-	-	4	33.6	1	-
13	Хархорин музей		1				1	5.6	-	-	1	5.6	-	-
14	Хөшөө цайдам музей						0	0.0	-	-	-	-	-	-
15	Улсын драмын эрдмийн театр		1				8	15.2	4	8.0	1	-	3	7.2
16	Үндэсний урлагийн их театр		1				8	29.0	-	-	3	4.5	5	24.5
17	Улсын дуурь бүжгийн		1				3	0.7						

Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	эрдмийн театр								-	-	1	-	2	0.7
18	Улсын филармони		1			3	21.0		-	-	1	-	2	21.0
19	Улсын хүүхэддэйн театр		1			8	177.1		-	-	4	159.9	4	17.2
20	Уран зургийн галлерей		1			7	2.3		-	-	3	-	4	2.3
21	Соёлын өвийн төв		1			2	22.2		-	-	1	21.3	1	0.9
22	Үндэсний номын сан		1			4	11.2		-	-	2	11.2	2	-
23	Хүүхдийн номын ордон		1			2	11.6		-	-	1	11.4	1	0.2
24	Чингис хааны өв, соёлын хүрээлэн		1			2	4.3		-	-	-	-	2	4.3
25	Нүүдлийн соёл иргэншлийг судлах ОУХ	1				0	0.0		-	-	-	-	-	-
26	Дэлхийн Өв Орхоны соёлын дурсгалт газар	1				0	0.0		-	-	-	-	-	-
27	Бурхан халдун уул ТХТГНХЗ	1				0	0.0		-	-	-	-	-	-
28	Монгол Алтай хадны ЗЦХЗБ	1				0	0.0							
	ДҮН	9	17	1	0	0	75	585.1	6	11.4	33	432.6	36	141.1

Хүснэгт 11. Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын нэгтгэл (сая.төгрөг)

Д/д	Харьяа байгууллага	Төлбөрийн актын товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
ТӨЛБӨРИЙН АКТ					
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ					
1	Соёлын яам	Барьцаа хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй.	0.5	СХОГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Ж.Отгонбат Г.Эрдэнэсүрэн
	Дүн		0.5		
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ					
1	Соёл урлагийн газар	Дуудлагын автомашиныг хувийн хэрэгцээнд ашиглан 1,913.9 мянган төгрөгийн зардал гаргасан.	1.9	Дарга Ахлах нягтлан бодогч	Ц.Нацагдолгор А.Түвшин
2	Монголын үндэсний музей	Гэрээт 24 ажилтанд олгосон ажлын хөлсөнд 1,530.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт тооцож, татвар дутуу ногдуулсан.	1.5	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Сүхбаатар Ж.Батсүх
3	Улсын драмын эрдмийн театр	Тэтгэвэрт гарсан ажилтанд төрийн албанд ажилласан жилийн нэмэгдэл, ур чадварын нэмэгдэл олгосон.	3.6	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Цэрэнсамбуу Л.Нина
		Өөр байгууллагад нягтлан бодогчоор ажилладаг хүнийг нягтлан бодогчийн албан тушаалд давхар ажиллуулж, амралтын олговор, ур чадварын нэмэгдэл олгосон.	3.4	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Цэрэнсамбуу Л.Нина
		Цалин, хөдөлмөрийн хөлснөөс илүү татвар суутгасан.	0.7	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Цэрэнсамбуу Л.Нина

		Бараа материал дутагдуулсан.	0.3	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Цэрэнсамбуу Л.Нина
	Дүн		11.4		
	Нийт дүн		11.9		
АЛБАН ШААРДЛАГА					
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ					
1	Хөрөнгө оруулалт	Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлангийн бусад эргэлтийн хөрөнгө дансанд 2016-2019 онуудад ашиглалтад орсон 9 төсөл, арга хэмжээний 6,108.1 сая төгрөг, улсын төсвийн санхүүжилт зогссон 1,319.1 сая төгрөг нийт 7,417.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй. Мөн 2020 онд ашиглалтад орсон 32 төсөл, арга хэмжээний 54,285.0 сая төгрөгийн барилга байгууламж бүртгэлтэй байна.	7,417.2	ТНБД СХОГ-ын дарга, Ерөнхий нягтлан бодогч	Г.Эрдэнэбат, Ж.Отгонбат, Г.Эрдэнэсүрэн
		Төсвийн хууль зөрчиж Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолын дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан 4,016.1 сая төгрөгийн хэрэгжээгүй 8 хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт барьцаа хөрөнгийн дансанд байршиж байна.	4,016.1	ТНБД СХОГ-ын дарга, СХОГ-ын ахлах мэргэжилтэн	Г.Эрдэнэбат, Ж.Отгонбат, Ш.Дэлгэрмаа
		Тайлант онд Засгийн газрын 2020 оны 253 дугаар тогтоолын дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан Чингис хааны музейн үзмэрүүдийг сэргээн, засварлах, сан хөмрөгийг нэмэгдүүлэх 2,000.0 төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын худалдан авах ажиллагаатай холбоотой дараах зөрчлүүд байна. Үүнд: 1.Хууль журмыг дагуу гүйцэтгэгч сонгон шалгараагүй, гүйцэтгэгч компани, хувь хүн тодорхойгүй, үнэлгээний хорооны шийдвэрээр зарим ажлуудыг нээлттэй тендер зарлахыг зөвлөсөн байхад ТНБД-ын А/72 дугаар тушаалаар шууд гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн 2. Төсөвт өртөг үндэслэл тооцоололгүй. 3. Үнийн санал аваагүй.	2,000.0	ТНБД СХОГ-ын дарга, СӨГ-ын дарга СХОГ-ын ахлах мэргэжилтэн	Г.Эрдэнэбат, Ж.Отгонбат, Б.Даваацэрэн Ш.Дэлгэрмаа
		Шилэн дансны цахим хуудсанд 61 мэдээлэл байршуулахаас хугацаандаа 46, хугацаа хоцроож 7, байршуулаагүй 8 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 3,409.3 сая төгрөгийн 26 ажил гүйлгээг байршуулаагүй байна	-	ТНБД СХОГ-ын дарга, СӨГ-ын дарга СХОГ-ын ахлах мэргэжилтэн	Г.Эрдэнэбат, Ж.Отгонбат, Б.Даваацэрэн Ш.Дэлгэрмаа
	Дүн		13,433.3		
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ					
1	Соёлын яам аппарат	Тайлант онд ТНБД-ын холбогдох тушаалуудаар үндсэн хөрөнгө худалдан авахад 631.1 сая төгрөг, урсгал засварт 200.2 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлаас зарцуулсан.	831.3	ТНБД Нягтлан бодогч	Г.Эрдэнэбат, Б.Рина
		Дээрх худалдан авалт, ажил үйлчилгээг зохион байгуулахдаа босго үнэд багтаах, нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор ТНБД-ын 44 тушаалаар 9.9-80.0 сая төгрөгийн худалдан авалтыг уламжлалт аргаар зохион байгуулж, харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан байна.		ТНБД Нягтлан бодогч	Г.Эрдэнэбат, Б.Рина
2	Соёл урлагийн газар	Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 119 мэдээлэл, хугацаа хоцроосон 28 мэдээлэл, 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй, шилэн дансны мэдээлэл санхүүгийн мэдээллээс зөрүүтэй илэрхийлэгдэж өмнөх зөвлөмжийг дутуу хэрэгжүүлсэн	-	Дарга Ахлах нягтлан бодогч	Ц.Нацагдолгор А.Түвшин
		Батлагдсан төсвөөс 25,036.0 мянган төгрөгийг дээд шатны төсөв захирагчийн зөвшөөрөлгүй шууд худалдан авалтаар зарцуулсан.	25.0	Дарга Ахлах нягтлан бодогч	Ц.Нацагдолгор А.Түвшин

3	Монголы үндэсний музей	Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 182/ШШ2020/01702 дугаар шийдвэрийг үндэслэн нэр бүхий ажилтанд ажилгүй байсан хугацааны 950.5 мянган төгрөгийн нөхөн төлбөрийг, байгууллагын төсвөөс олгосон байна.	0.9	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Сүхбаатар Ж.Батсүх
		Шилэн дансны нэгдсэн цахим системд 28 мэдээллийг хоцроож, 4 мэдээллийг байршуулаагүй ба 5 сая төгрөгөөс дэшш үний дүн бүхий 1 удаагийн 16,374.4 мянган төгрөгийн орлогыг мэдээлээгүй байна.	16.4	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Сүхбаатар Ж.Батсүх
4	Байгалийн түүхийн музей	"Түрээсийн гэрээ"-ий 3.6-д "Түрээслүүлэгч нь түрээсийн төлбөрийн 40 /дөч/ хувь болох 360.0 мянган төгрөгийг төлбөр орсноос хойш ажлын 5 едрийн дотор Улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлээгүй.	0.3	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Н.Зоригтбаатар Ш.Дуламсүрэн
		Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлд заасан 18 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Н.Зоригтбаатар Ш.Дуламсүрэн
5	Богд хааны ордон музей	Шилэн дансны тухай хуулийн дагуу 173 мэдээлэл оруулахаас 40 мэдээлэл хугацаа хоцроосон.	-	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Ц.Эрдэнэбаатар Б.Эрдэнэчимэг
6	Дүрслэх урлагийн музей	Өмнөх аудитаар өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	-	Ерөнхий нягтлан бодогч	Б.Ану
		Шилэн дансны тухай хуулийн дагуу 170 мэдээлэл оруулахаас 33 мэдээлэл хугацаа хоцроосон байна.	-	Ерөнхий нягтлан бодогч	Б.Ану
7	Монголын театрын музей	Өмнөх аудитаар өгсөн төсөвт зардлын мөнгөн гүйлгээ нь анхан шатны цахим "и" баримтгүй, худалдан авалтын болон орлогын дүнг цахим "и" баримттай тулган хянах, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах тухай зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй буюу тайлант онд 116.4 мянган төгрөгийн худалдан авалт, 421.0 мянган төгрөгийн билетийн орлого цахим баримтгүй, анхан шатны баримтыг урьдчилан дугаарладаггүй байна.	0.5	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Наранжаргал Р.Очмандах
		Шилэн дансны нэгдсэн цахим системд 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн буюу 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 9 удаагийн 139,952.1 мянган төгрөг, зардал гаргах 2 удаагийн 2,080.0 мянган төгрөг, тасалбарын үнийг шинэчлэн тогтоосон шийдвэрийг мэдээлээгүй байна.	142.0	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Наранжаргал Р.Очмандах
8	Чойжин ламын сүм музей	Нийт цалингийн дүн нийгмийн даатгалын тайлангаас зөрүүтэй тайлагнасан байна. 2020 оны жилийн эцсийн үлдэгдэл нийгмийн даатгалын тайлангаар 1,096.8 мянган төгрөг, санхүү байдлын тайлангаар 1,466.8 мянган төгрөг, НДШ өглөгийн зөрүү 370.0 мянган төгрөгийн зөрүүтэй байна.	0.4	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Отгонсүрэн О.Хэрлэн
		Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.	-	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Отгонсүрэн О.Хэрлэн
		Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,677.2 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 82 хувь биелэгдсэн байна.	-	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Отгонсүрэн О.Хэрлэн
		Шилэн дансны цахим хуудсанд 70,769.9 мянган төгрөгийн и-баримтыг зарлагын баримтуудтай тулгахад 33,236.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.	33.2	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Отгонсүрэн О.Хэрлэн
9	Улсын драмын эрдмийн театр	Шилэн дансанд мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан.	-	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Цэрэнсамбуу Л.Нина

10	Үндэсний урлагын их театр	Тайлант оны эцэст 4,470.0 мянган төгрөгийн шатахууныг нөөцлөн, үлдэгдлээр тайлагнасан.	4.5	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Г.Цоггэрэл Н.Батсүрэн
		Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан.	-	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Г.Цоггэрэл Н.Батсүрэн
		Шилэн дансны цахим хуудсанд 173 мэдээлэл оруулахаас 57 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан.	-	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Г.Цоггэрэл Н.Батсүрэн
11	Улсын дуурь бүжгийн эрдмийн театр	Шилэн дансны цахим хуудсанд 3 мэдээлэл байршуулаагүй.	-	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Ц.Төвшинтөгс Н.Анхтөр
12	Улсын филармони	Шилэн дансны цахим хуудсанд 126 мэдээлэл оруулахаас 34 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан.	-	Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ерөнхий нягтлан бодогч	С.Баттулга Б.Сонинцэцэг
13	Улсын хүүхэддэйн театр	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт бүрэн нийцээгүй, өөрчлөн сайжруулах шаардлагатай болсон.	-	Дарга Ерөнхий нягтлан бодогч	М.Отгончимэг Г.Алтанчимэг
		Баянхонгор аймгийн Тэмүүжин театраас хүлээн авсан хүүхэддэйн жүжгийн франчайзын орлого 3,000.0 мянган төгрөгийг мөн Дэлхийн зөн ОУБ-аас орж ирсэн тоглолтын тасалбарын үнэ 500.0 мянган төгрөгийг и-баримтаар бүртгээгүй.	3.5	Дарга Ерөнхий нягтлан бодогч	М.Отгончимэг Г.Алтанчимэг
		Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй. Мэдээлэл дутуу оруулсан.	139.4	Дарга Ерөнхий нягтлан бодогч	М.Отгончимэг Г.Алтанчимэг
		Худалдан авах ажиллагааны нээлттэй тендер шалгаруулалтын журам зөрчсөн.	17.0	Дарга Ерөнхий нягтлан бодогч	М.Отгончимэг Г.Алтанчимэг
14	Монголын уран зургийн галерей	Монголын уран зургийн галерейн Түүх соёлын дурсгалт зүйлст 2014 онд дахин үнэлгээ хийж нэмэгдэл болох 14,314,724.3 мянган төгрөгийг санхүүгийн тайланд хөрөнгө /бүтээл/ бүрээр биш нэг бөөн дүнгээр тусгасан.	-	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Сарантуяа Л.Болдбаатар
		Монголын уран зургийн галерейн музейн үзмэр бүртгэлийн регистр программд 3659 ширхэг 15,073,161.4 мянган төгрөгийн хөрөнгө байгаа бол санхүүгийн тайлангаар 3,366 ширхэг 15,249,905.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.	-	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Сарантуяа Л.Болдбаатар
		Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.	-	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Б.Сарантуяа Л.Болдбаатар
15	Соёлын өвийн үндэсний төв	Тайлант хугацаанд оруулбал зохих 164 мэдээллээс 28 мэдээллийг хугацаа хоцроож, 21,621.3 мянган төгрөгийн ажил гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.	21.3	Захирал Нягтлан бодогч	Г.Энхбат Ч.Өнөртогтох
16	Үндэсний номын сан	Байгууллагаас шилэн дансанд мэдээлэх 173 мэдээллээс 80 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.	-	Захирал Ахлах нягтлан бодогч	Б.Ичинхорлоо Э.Энхзул

Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

		2020 онд багаж, техник хэрэгслийн зардалд 30,000.0 мянган төгрөг батлагдсан байх бөгөөд харьцуулалтын аргаар цахим тендер зарлаж гүйцэтгэгчийг шалгаруулаагүй 11,154.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шууд худалдан авсан.	11.2	Захирал Ахлах нягтлан бодогч	Б.Ичинхорлоо Э.Энхзул
17	Хүүхдийн төв номын сан	Шилэн дансны цахим хуудсанд мэдээ, мэдээлэл оруулаагүй, хугацаа хоцроосон.	11.4	Захирал Нягтлан бодогч	Б.Энхмарт Г.Оюунтунгалаг
18	Хархорум музей	Шилэн дансны цахим хуудсанд 5.6 сая төгрөгийн 1 ажил гүйлгээ байршуулаагүй.	5.6	Захирал Нягтлан бодогч	Л.Шинэбат М.Эрдэнэсолонго
	Дүн		1,263.9		
ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БОЛОН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ					
1	Монгол кино нэгтгэл ТӨААТҮГ	Шилэн дансны тухай хуулийн дагуу 170 мэдээлэл оруулахаас 49 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан. Шилэн дансны цахим системийн "бусад" хэсгийн 1-д "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл" -ийг байршуулах гэсэн нүдэнд "Мэдэгдэл гаргах үйл ажиллагаа явагдаагүй мэдэгдэл гаргаагүй" гэж хаасан байна.	53.6	Захирал Ерөнхий нягтлан бодогч	О.Түвшиндэмбэрэл Г.Төрбат
		Нэр бүхий 22 байгууллага, хувь хүнээс авах төлөгдөх эсэх нь тодорхойгүй, эрсдэлтэй авлага байна.	28.2	Захирал Ерөнхий нягтлан бодогч	О.Түвшиндэмбэрэл Г.Төрбат
1	Дүн		81.8		
ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН					
1	Кино урлагийг дэмжих сан	Тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Кино урлагийг дэмжих сан байгуулагдаж, 2020 оны төсвийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр тус санд 10,000.0 сая төгрөгийн төсөв баталсан. Кино урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах журам батлагдаагүйгээс сангийн хөрөнгийг зарцуулаагүй, үлдэгдлийг улсын төсвийн дансанд төвлөрүүлээгүй байна.	10,000.0	Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга Төсвийн ерөнхий нягтлан бодогч	Ж.Отгонбат Г.Эрдэнэсүрэн
	Дүн		10,000.0		
	Нийт дүн		24,779.0		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 04 дугаар сарын 26 № 115/АОН0001
САН-2021/33/СТА-ТЭС

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Завхан Баянтэс сумын соёлын төвийн барилгын хөрөнгө оруулалтын ажлын хэмнэлт 540,057.0 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн зарлагын хэмнэлтэд тооцно", 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл"-ийг төвлөрүүлнэ гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хөрөнгө оруулалтын ажлын хэмнэлтээс үүссэн 540,057.0 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Соёлын сайд Ч.Номин, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26 № 597/АОИ/0001
САГ-0021/33/СТА-ТЭЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Кино урлагийг дэмжих сан байгуулагдаж, 2020 оны төсвийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр тус санд 10,000.0 сая төгрөгийн төсөв баталсан. Кино урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах журам батлагдаагүйгээс сангийн хөрөнгийг зарцуулаагүй, үлдэгдлийг улсын төсвийн дансанд төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т “Кино урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална” гэж заасан боловч тус журам гараагүй байна. Мөн Кино урлагийг дэмжих тухай хууль батлагдаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Кино урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах журмыг холбогдох байгууллагаар батлуулж мөрдөх, эрх зүйн орчныг бий болгож, холбогдох арга хэмжээ авч зөрчлийг арилган биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёлын сайд Ч.Номин, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

001081447



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 598/АО110001

Улаанбаатар хот

С.ӨТ-2021/33/СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд 61 мэдээлэл байршуулахаас хугацаандаа 46, хугацаа хоцроож 7, байршуулаагүй 8 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 3,409.3 сая төгрөгийн 26 ажил гүйлгээг байршуулаагүй байна.


Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёлын сайд Ч.Номин, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ЗАНДАНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26 № 593/АОН0001
САГ-2021/33/СТА-ТЭЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлангийн бусад эргэлтийн хөрөнгө дансанд 2016-2019 онуудад ашиглалтад орсон 9 төсөл арга, хэмжээний 6,108.1 сая төгрөг, улсын төсвийн санхүүжилт нь зогссон 1,319.1 сая төгрөг, нийт 7,417.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй, 2020 онд ашиглалтад орсон 32 төсөл, арга хэмжээний 54,285.0 сая төгрөгийн барилга байгууламж бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэн", 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.8-д "хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Барилга байгууламжийг ашиглагч байгууллагад шилжүүлэн өгөх, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч, албан шаардлагын хэрэгжилтийг хангуулан, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёлын сайд Ч.Номин, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26 № 600/ҮОНД0001
САГ- 2021/33/СТА-ТЭЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолын дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан 4,016.1 сая төгрөгийн 8 хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт барьцаа хөрөнгийн дансанд байршиж байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёлын сайд Ч.Номин Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ЗАНДАНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 601/А0110001

Улаанбаатар хот

САГ-2021/33/СТЭ-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын 2020 оны 253 дугаар тогтоолын дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан Чингис хааны музейн үзмэрүүдийг сэргээн, засварлах, сан хөмрөгийг нэмэгдүүлэх 2,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчийг холбогдох журмын дагуу сонгон шалгараагүй, гүйцэтгэгч компани, хувь хүн тодорхойгүй, үнэлгээний хорооны шийдвэрээр зарим ажлуудыг нээлттэй тендер зарлахыг зөвлөсөн байхад Төрийн нарийн бичгийн даргын А/72 дугаар тушаалаар шууд гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2-т Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ, 46.1.3-т "үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлтэд үндэслэн гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёлын сайд Ч.Номин, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26 № 602/АОН10001
СЯГ-2021/33/СТА-ТЭЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн төсвөөс үндсэн хөрөнгө худалдан авахад 631.1 сая төгрөг, урсгал засварт 200.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа босго үнэд багтаах, нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийж Төрийн нарийн бичгийн даргын 44 тушаалаар 9.9-80.0 сая төгрөгийн худалдан авалтыг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан байна.

Энэ нь төсийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", сангийн сайдын 2014 оны Тушаалд өөрчлөлт оруулах тухай 55 дугаар тушаалаар баталсан "төсвийн зарлагын эдийн засгийн ангилал", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйл Худалдан авах ажиллагааны журмыг сонгох 8.1-д "Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараах босго үнийг тогтооно", 8.1.1-д "харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар", 8.5-д Энэ хуулийн "8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", 21 дүгээр зүйл Тендерийн урилгыг нийтэд зарлан мэдээлэх 21.1-т "Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлагын хэрэгжилтийг ханган, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёлын сайд Ч.Номин, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\0.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardлага\2021\0426auditin 3-R Gazar61.Docx

001081435